



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО**  
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

БАТЛАВ.

“.....

.....” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

БАТЛАВ.

“.....

.....” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

202.. оны ... дугаар сарын ...-ний өдөр

№....

Улаанбаатар хот

Энэхүү АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ /цаашид “гэрээ” гэх/-г

**Нэг талаас:** “.....” /РД: ...../, цаашид  
“захиалагч” гэх/;

**Нөгөө талаас:** “.....” /РД: ...../, цаашид “гүйцэтгэгч тал”,  
хамтад нь “талууд” гэх/ нар Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг үндэслэн  
талууд дараах нөхцөлийг харилцан тохиролцож дор дурдсан нөхцөлөөр энэхүү  
гэрээг байгуулав.

**НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Гэрээний зорилго: Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь .....-ын ..... хотод  
болох ..... (цаашид ..... эсхүл “.....” гэх) ..... ажлыг  
гүйцэтгэх, нөгөө талаас захиалагч нь энэхүү ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай  
төлбөрийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Гэрээний нэр томьёоны тайлбар: энэхүү гэрээнд дурдсан дараах нэр  
томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1.“доголдол” гэж гэрээгээр тогтоосон зохиогчийн эрх зөрчсөн; арга  
хэмжээ зохион байгуулалтын талаарх гомдол, шүүмжлэл нь олон нийтийн  
мэдээллийн хэрэгслийг хамарсан;

1.2.2.“ажил гүйцэтгэх боломжгүй болсон” гэж гүйцэтгэгч төрийн бус  
байгууллага, компани, холбоо татан буугдсан, гэнэтийн болон давагдашгүй хүчин  
зүйл, хүнд нөхцөл байдал бий болсон, гэрээг цаашид үргэлжлүүлэх боломжгүй  
нөхцөл байдлыг;

1.2.3.“гэрээний ноцтой зөрчил” гэж Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан  
хориглосон үйлдэл гаргасан, үйлдэл, эс үйлдлийг тус тус ойлгоно.

1.2.4.“гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл” гэж Монголын Үндэсний  
худалдаа аж үйлдвэрийн танхимаас баталсан “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин  
зүйл (Force majeure) болон Хүнд нөхцөл байдал “Hardship”-ыг гэрчлэх журам”-ын  
1.2.1 дэх заалтад заасныг;

1.2.5.“хүнд нөхцөл байдал буюу Hardship” гэж Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас баталсан “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл (Force majeure) болон Хүнд нөхцөл байдал “Hardship”-ыг гэрчлэх журам”-ын 1.2.2 дахь заалтад заасныг.

1.3.Баримтлах зарчим: талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг дагаж мөрдөнө. Үүнд:

1.3.1.гэрээт ажлыг мэргэжлийн өндөр төвшинд хийж гүйцэтгэх;

1.3.2.ашиглаж буй аливаа бараа, үйлчилгээ нь зохиогчийн эрхийн зөрчилгүй байх;

1.3.3.гэрээт ажлыг тохиролцсон хугацаанд хийж гүйцэтгэх;

1.3.4.үйлдвэрлэлийн осол, гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх;

1.3.5.зохион байгуулалт нь оролцогчдын аюулгүй байдал, тав тухтай байдлыг бүрдүүлсэн байх;

### **ХОЁР.ГЭРЭЭТ АЖИЛ, АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА**

2.1.Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний хүрээнд дараах ажлыг дурдсан хугацааны дагуу хийж гүйцэтгэнэ:

2.1.1.....;

2.1.2. ....;

2.1.3. ....;

.....;

2.1.4. ....;

.....;

2.1.5. ....;

.....;

2.2.Энэхүү гэрээг ..... оны ....-р сарын ....-ний өдрөөс ..... оны ....-р сарын ....-ний өдрийг дуустал хугацаатай байгуулав.

2.3.Талууд харилцан тохиролцож энэхүү гэрээний 2.2-т заасан хугацааг сунгаж болно. Энэ тохиолдолд нэмэлт гэрээ байгуулна.

### **ГУРАВ.ГЭРЭЭТ АЖЛЫН САНХҮҮЖИЛТ**

3.1.Гэрээт ажлын төлбөр нь ..... (.....) төгрөг байна.

3.2.Захиалагч нь энэхүү гэрээний 3.1-д заасан төлбөрийг Гүйцэтгэгчид дараах байдлаар шилжүүлнэ:

3.3.1.гэрээний 3.1-д заасан гэрээний урьдчилгаа төлбөр болох төлбөрийн 70 хувийн төлбөр болох ..... төгрөгийг гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор Гүйцэтгэгчийн .....банкны MN.....тоот дансанд;

3.3.2. гэрээний 3.1-д заасан төлбөрийн 30 хувийг гэрээт ажил дуусаж, энэхүү гэрээнд заасан гэрээний тайлан, санхүүгийн баримт, бүрдлийг шалгаж тооцоо нийлсний үндсэн дээр талууд гэрээ дүгнэсэн акт үйлдэж тайланг .....-нд хүргүүлснээс хойш 10 хоногийн дотор Гүйцэтгэгчийн ..... банкны MN .....тоот дандсанд тус тус шилжүүлнэ.

3.4.Гүйцэтгэгч энэхүү журмын 3.1-т заасны дагуу шилжүүлсэн гэрээний төлбөрийг Гүйцэтгэгч зөвхөн энэхүү гэрээний 2.1 -д заасан үүргээ хэрэгжүүлэх зорилгоор зарцуулна.

3.5.Энэхүү гэрээний 3.1-д заасан төлбөрт аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, банкны шилжүүлгийн шимтгэл болон холбогдох бусад татвар, хураамж багтсан болно.

3.6.Захиалагч тал төлбөрийг гэрээнд заасан захиалагчийн дансанд шилжүүлэхдээ гүйлгээний утга дээр захиалагч байгууллагын нэр, регистрийн дугаар, энэхүү гэрээний дугаарыг бичнэ.

## **ДӨРӨВ.ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

### **4.1.Захиалагч дараах эрхтэй:**

4.1.1.Захиалагч нь Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй бөгөөд ажлын төлөвлөгөө, хуваарийн дагуу хугацаандаа явагдаж байгаа эсэхэд хяналт тавих;

4.1.2.ажлын үр дүнг хүлээж аваад доголдолтой хийгдсэн гэж үзвэл доголдолтой хэсгээр засах, сайжруулахыг шаардах;

4.1.3.ажлын доголдлыг засахыг Гүйцэтгэгч талаас шаардах, шинээр гүйцэтгүүлэх;

4.1.4.ажлын үр дүнг хүлээж авснаас хойш хүлээн авах үед илрүүлэх боломжгүй доголдлын тухай гэрээний хугацаанд гомдлын шаардлага гаргах;

4.1.5.олон нийтийн зүгээс Гүйцэтгэгчийн ажил, үүргийн талаарх гомдол 10-аас дээш ирвэл Захиалагч тухайн хэсгийг засан сайжруулахыг шаардах;

4.1.6.доголдлыг арилгаагүй бол гэрээний төлбөрийг бууруулан олгох

4.1.7.гэрээний мөнгөн дүнд тохируулан өөрчлөлт оруулах;

4.1.8 гүйцэтгэгч сануулсан доголдлыг 4 (дөрөв) буюу түүнээс дээш удаа засаж биелүүлээгүй, ажлыг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон, ноцтой зөрчил гаргасан бол гэрээг цуцлах.

### **4.2.Захиалагч дараах үүрэгтэй:**

4.2.1.гэрээнд заасан хугацаанд тохиролцсон төлбөрийг шилжүүлэх;

4.2.2.гүйцэтгэгчийг гэрээнд заасан хугацаанд ажиллах боломжоор хангах;

4.2.3.ажил, үүрэгт өөрчлөлт оруулах хүсэлтээ бичгээр мэдэгдэх бөгөөд энэ гэрээний 3.1-д заасан мөнгөн дүнгийн хэмжээнээс хэтрэхгүй байх;

4.2.4.гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээж авах;

4.2.5.захиалагч тал энэхүү гэрээнд заасан ажил, үүргийг биелүүлэхэд төрийн эрх бүхий байгууллагатай харилцаж, шаардлагатай тусламж, дэмжлэгийг гүйцэтгэгчид үзүүлэх, холбогдох мэдээллээр хангах үүрэгтэй.

#### **4.3.Гүйцэтгэгч дараах эрхтэй:**

4.3.1.гэрээний 3.1-д заасан төлбөрийг шилжүүлэхийг Захиалагчаас шаардах;

4.3.2.Захиалагчаас ажил, үүрэгт өөрчлөлт оруулах эсэхийг бичгээр лавлан, хуанлийн 3 хоногийн дотор саналаа ирүүлэхийг шаардах;

4.3.3.энэхүү гэрээнд заасан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой мэдээ, мэдээлэл, бусад тусламж, дэмжлэгийг захиалагчаас хүсэх;

#### **4.4.Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:**

4.4.1.Захиалагчийн баталсан төлөвлөгөө, хөтөлбөр болон энэхүү гэрээнд заасан хугацааны дагуу ажлыг гүйцэтгэх;

4.4.2.Гүйцэтгэгч гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгэхдээ 1.3-т заасан зарчмуудыг баримталж гүйцэтгэх

4.4.3.ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх;

4.4.4.захиалагчийн шаардсанаар ажлын доголдлыг арилгах;

4.4.5.ажлын үр дүнгийн доголдлыг арилгах зардлыг хариуцах;

4.4.6.ажил хүлээлцэх актаар ажлын үр дүнг хүлээлцэх;

4.4.7.ажлын үр дүнд муугаар нөлөөлөх нөхцөл байдлын талаар Захиалагчид нэн даруй мэдэгдэх;

4.4.8.ажил дууссаны дараа харилцсан тохиролцсон хэлбэрээр дагуу ажлын тайлан болон гэрээ дүгнэсэн акт үйлдэж, зардлын задаргааг нягтлан бодох бүртгэлийн шаардлагад нийцүүлэн төлбөрийн баримт болон холбогдох бусад баримтыг Захиалагчид ирүүлнэ. Ажлын тайлан, нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь тухайн арга хэмжээнд зарцуулсан нийт мөнгөн дүнгийн хэмжээнд байна.

4.4.9.өөрийн ажилчид болон туслан гүйцэтгэгч нарыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдөж ажиллахыг шаардах;

4.4.10.Гүйцэтгэгч тал шаардах эрхээ хэрэгжүүлэхдээ олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгсэл ашиглаж хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдахгүй байх үүрэгтэй.

### **ТАВ.ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

5.1.Талуудын хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу урьдчилан харж зохицуулагдах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдалд аль аль тал нь ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

5.2.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдал арилмагц талууд гэрээний үүргээ биелүүлэх үүрэгтэй.

5.3.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл нь үүрэг гүйцэтгэх хугацаа хойшлогдох, хохирол, гэрээний хариуцлагаас чөлөөлөх бөгөөд гэрээний үндсэн үүргээс чөлөөлөхгүй.

5.4.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын гэрчилгээгээр нотолно.

### **ЗУРГАА. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

6.1.Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд заавал бичгээр үйлдэж, гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулан гэрээнд хавсаргах бөгөөд хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

6.2.Гэрээний хавсралт нь гэрээний салшгүй нэг хэсэг бөгөөд түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

6.3.Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахдаа гэрээнд заасан хаяг, и-мэйл, утсаар холбогдож санал тавина.

### **ДОЛОО. ГЭРЭЭНЭЭС ТАТГАЛЗАХ, ЦУЦЛАХ, ХАРИУЦЛАГА**

7.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ чин шударгаар сахин биелүүлнэ.

7.2.Гэрээний хэлэлцээрийн үе шатанд мэдээлэл солилцсонтой холбоотойгоор үүсэх үр дагаврыг талууд хариуцахгүй.

7.3.Гүйцэтгэгч тал гэрээгээр тогтоосон хугацааны дотор ажил үүргийг бүрэн гүйцэтгээгүй бол хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө.

7.4.Энэ гэрээний 4.1.8-д заасан үндэслэлээр гэрээг цуцалсантай холбоотой Гүйцэтгэгчид учирсан зардал, хохирол, үр дагаврыг Захиалагч хариуцахгүй.

7.5.Энэ гэрээний 4.1.8-д зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцалсан бол цуцалсан хэмжээнд ажлын гүйцэтгэлийг үнэлж үлдэгдэл мөнгийг Захиалагчид шилжүүлнэ. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний талаар маргавал Захиалагчийн сонгосон үнэлгээ хийх эрхтэй этгээдийн үнэлгээг баримтална. Үнэлгээтэй холбоотой зардлыг талууд тэнцүү хариуцна.

7.6.Гүйцэтгэгч ажил, үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд Захиалагч гэрээнээс татгалзах эрхтэй ба шилжүүлсэн эд хөрөнгө, мөнгөн дүнг буцаан шилжүүлэх үүрэгтэй. Гэрээнээс татгалзсантай холбоотой нэмэлт зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

### **НАЙМ. БУСАД**

8.1.Гэрээний явцад маргаантай асуудал гарвал хоёр тал эвийн журмаар харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Хэрэв шийдэлд хүрэхгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

8.2.Гэрээг 3 хувь үйлдэж хувь тус бүр хууль зүйн хүчин төгөлдөр байна.

8.3.Гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуульд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Гүйцэтгэгчийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд

тохиролцон гэрээний дагуу Гүйцэтгэгчид төлөх хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.

8.4.Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж гэрээнд заасан хугацаа дууссанаар гэрээний хугацаа дуусгавар болно. Гэрээний хугацаа дуусгавар болсон нь гэрээнээс үүдэлтэй шаардах эрх дуусгавар болох үндэслэл болохгүй.

8.5.Гэрээний дүгнэсэн актыг захиалагчтай хамтран хийж гэрээг дүгнэх бөгөөд санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг хууль журмын дагуу хөтөлж и-баримтыг Захиалагч талд олгоно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагч:

“.....” ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

Худалдагч:

“.....” ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

Хаяг:

Улаанбаатар хот, .....  
дүүрэг, ..... дугаар  
хороолол, .....-р байр, .....  
тоот.

Цахим шуудан: .....

Утас: .....

Хаяг:

Улаанбаатар хот, .....  
дүүрэг, ..... дугаар  
хороолол, .....-р байр, .....  
тоот.

Цахим шуудан: .....

Утас: .....